

*“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар, цаг  
ямагт, хүн бүрт”*

**Хүний эрхийн Үндэсний Комиссын  
Дундговь аймаг дахь референт  
Т.Баярцэцэг**



[www.mn-nhrc.org](http://www.mn-nhrc.org)

# Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль

- ▶ 24.1. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан жендэрийн эрх тэгш байдлын тухай заалтын хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавих, эдгээр хууль тогтоомж зөрчсөнтэй холбоотой гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрлэх үйл ажиллагааг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулиар олгосон бүрэн эрхийнхээ дагуу хэрэгжүүлнэ.

# Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний Зөвлөмж

- ▶ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн П.Оюунчимэгээр ахлуулсан ажлын хэсэг "Хүний эрхийн нээлттэй өдөр" арга хэмжээг 2019 оны 06 дугаар сарын 19, 20, 21-ны өдрүүдэд Дундговь аймагт зохион байгуулсан.
- ▶ Комиссоос Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлж буй нөхцөл байдалтай газар дээр нь танилцах, төрийн албаны үйлчилгээ, хөдөлмөрийн харилцаанд жендэрийн тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалт, ажлын байран дахь бэлгийн дарамт зэрэг хүний эрхийн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн байгууллагат хяналт шалгалт хийсэн.
- ▶ Хяналт, шалгалтад аймгийн ИТХурал, АЗДТГазар, Сайнцагаан сумын ИТХ, ЗДТГ, аймгийн Эрүүл мэндийн газар, Боловсрол, соёл урлагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хүнс, хөдөө, аж ахуйн газар зэрэг төрийн байгууллагууд хамрагдсан.

# Жендэрийн сургагч багш бэлтгэсэн



Хүний эрхийн Үндэсний Комисс 2017 онд орон нутагт 19 “Жендэрийн сургагч багш” бэлтгэсэн.

# Ойлгоё хүндэлье

- ▶ НҮБ-ын санаачилгаар дэлхий нийтээр жил бүр зохион байгуулдаг Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян 11 сарын 25-аас 12 сарын 10-ны өдрүүдэд үргэлжилдэг.
- ▶ Жендерт суурилсан хүчирхийллийн эсрэг 16 хоногийн аяныг “ОйлГОЁ ХҮНдэлье” уриан дор ХЭҮК-ын аймаг дахь референт, аймгийн ЗДТГазар, Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрууд хамтран зохион байгуулж байна.



# Ойлгоё хүндэлье

- ▶ Тус аяны хүрээнд аймгийн төрийн захиргааны байгууллагын удирдлагууд 2019 оны 12 сарын 02-ны өдөр нэгдэж, удирдлагуудад Ойлгоё хүндэлье 2020 оны хуанли, ажлын байрны бэлгийн дарамт гэж юу бэ? тараах материал тус бүр 60ш бэлтгэж тарааж, аяны цагаан туузыг зүүлгэлээ.



# Ойлгоё хүндэлье

- ▶ Дундговийн амьдрал сонинд Жендэрийн ойлголт болон гэр бүлийн хүчирхийлэл, ажлын байран дахь бэлгийн дарамт сэдвээр нийтлэл боловсруулж, нийтлүүлсэн. Сонин 7 хоног бүр 1000 хувь хэвлэгдэн орон даяар тараагддаг.



Гэр бүлийнхээ төлөө ойлгоё хүндэлье, ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлье сурталчилгааны самбар хийлээ.





Дундговь аймаг дахь ХЭҮК-оос “Жендэрийн сургагч багшаар” бэлтгэгдсэн төрийн захиргааны байгууллагуудын дунд холимог багийн боллейболын тэмцээн зохион байгуулж, оролцогч байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, алба хаагч, иргэдэд хүний эрхийн талаар сурталчлан таниулах, хүний эрхийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх, ажлын алжаал тайлах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд зориулж, 2019 оны 12-р сарын 06-ны өдөр зохион байгуулав.



*Анхаарал тавьсанд баярлалаа.*